

Х. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Д/д	Асуулт	Хариулт	Алхам
Хэсэг 1. Байгаль орчны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хамаарах хөдөлмөр эрхлэлт (Байгаль орчны дараах төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг 2014 онд зах зээлийн зориулалтаар үйлдвэрлэсэн эсэхийг асууж хариултыг авна.)			
1	Танай байгууллага сэргээгдэх эрчим хүч болон сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийг үйлдвэрлэсэн үү? <i>/салхи, нар, ус, биомасс, хатуу хог хаягдлаас эрчим хүч, дулаан, түлш үйлдвэрлэх үйл ажиллагаа; салхины цахилгаан үүсгүүрийн тоног төхөөрөмж, нарны дулааны тоног төхөөрөмж, нарны толь, биомасс-шатаах үйлдвэрийн бойлуур зэргийн үйлдвэрлэлийг хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
2	Танай байгууллага эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлсэн үү? <i>/эрчим хүчний хэмнэлттэй үйлдвэрийн тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, барилга, тээврийн хэрэгсэл, гэрэлтүүлэг зэрэг эрчим хүчний хэрэгсэлгээ бууруулах бүтээгдэхүүн, түүний засвар, үйлчилгээ; барилгын эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх, эрчим хүчийг хадгалах, түгээх үр ашгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа хамаарна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
3	Танай байгууллага хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлсэн үү? <i>/хатуу хог хаягдлыг дахин боловсруулж, чанарыг сайжруулах; хоёрдогч түүхий эд материалыг цуглуулах сав, баглаа боодол, хог хаягдлын уут, хайрцаг; хог хаягдлыг цуглуулах тоног төхөөрөмж зэргийг үйлдвэрлэх; хуучин хувцас, хэрэгсэл, ном, тээврийн хэрэгслийн худалдах зэргээр байгалийн нөөцийн хэрэгсэлгээ бууруулах бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
4	Танай байгууллага байгаль орчны бохирдол, агаарт ялгаруулах хаягдлыг бууруулах урьдчилан сэргийлэх, арилгах бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлсэн үү? <i>/байгаль орчны бохирдол, химийн хорт бодис, хог хаягдал (ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж, үйлдвэрийн бохир усыг цэвэрлэх тоног төхөөрөмж) үүсгэгчийг устгах, бууруулах, бохирдуулагч, аюултай хог хаягдлыг байгаль орчноос зайлуулах бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ; агаарын бохирдлыг бууруулахад ашиглаж буй бүтээгдэхүүн (хаягдал хий шингээгч төхөөрөмж, катализатор хувиргагч, бохирдол устгах конденсатор, шүүлтүүр, шингээгч, илүү хэмнэлттэй мод хатаах зуух, цэнэглэдэг зай зэргийн үйлдвэрлэл)-ий үйлдвэрлэл, үйлчилгээг хамруулна. /</i>	Агаарын бохирдол А Усны бохирдол Б Бусад В (бичих)	Хэрэв 1-9-р асуултыг бүгдийг "2" гэж хариулсан бол "Хэсэг 2"-руу шилжинэ.
5	Танай байгууллага байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалах бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг эрхэлсэн үү? <i>/агаар, хөрс, ус, усны нөөц, ойн нөөц, ашигт малтмалын нөөц, биологийн олон янз байдал, байгаль хамгаалах (ойжуулах зорилгоор мод тарих, ургуулах, эко аялал жуулчлал); газар болон усны менежмент; агаар, ус, хөрсний чанарын хяналт, үнэлгээ; байгаль орчныг хамгаалах судалгаа, шинжилгээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг хамруулна. /</i>	Агаар А Хөрс Б Усны нөөц В Ойн нөөц Г Ашигт малтмал Д Биологийн олон янз байдал Е	
6	Танай байгууллага хөдөө аж ахуйн органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн үү? <i>/химийн бордоо, химийн хор (пестицид), даавар, мал аж ахуйд ашигладаг антибиотик зэрэг ургамлын өсөлтийг зохицуулагч бүтээгдэхүүн, хувиргасан амьд организм, зохиомол хээлтүүлэг зэргийг огт ашиглаагүй эсвэл маш бага хэмжээгээр ашиглан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
7	Танай байгууллага байгаль орчны менежмент, сургалт зохион байгуулах, хичээл заах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаанд оролцсон уу? <i>/байгаль орчны холбогдолтой дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх; ногоон технологи, ногоон туршлагатай холбоотой боловсрол олгох, сургалт явуулах; байгаль орчны асуудлаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
8	Танай байгууллага байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийн жагсаалтад тусгагдсан тоног төхөөрөмжийг худалдсан уу?	Тийм 1 Үгүй 2	
9	Танай байгууллага байгаль орчны бусад төрлийн үйл ажиллагаанд оролцсон уу? <i>/байгаль орчинд ээлтэй, байгалийн нөөцийг хамгаалах чиглэлийн өмнө нь дурдагдаагүй байгаль орчны бусад бараа, үйлчилгээг хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
10	Танай байгууллага 1-9-р асуултад дурдсан байгаль орчны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээнээс (аж ахуйн нэгжийн нэгж хоорондын шилжүүлэг болон бараа, үйлчилгээ) ашиг олсон уу?	Тийм 1 Үгүй 2	12
11	Танай байгууллага нийт ашгийнхаа хэдэн хувийг байгаль орчны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээнээс олсон бэ?	<input type="text"/> %	
12	Танай байгууллагын ажилчдын хэдэн хувь нь 1-9-р асуултад дурдсан байгаль орчны бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллаж байна вэ?	<input type="text"/> %	

Д/Д	Асуулт	Хариулт	Алхам
Хэсэг 2. Байгаль орчны үйл ажиллагаанд хамаарах хөдөлмөр эрхлэлт			
13	Танай байгууллага сэргээгдэх эрчим хүчний техник технологи, туршлагыг ашигласан уу? <i>/сэргээгдэх эрчим хүч, дулаан, түлшийг ашиглах технологи, туршлагын хэрэглээ (салхи, нар, биомасс, хатуу хог хаягдал, ус, усан цахилгаан станцаас цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагааны)-г хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
14	Танай байгууллага эрчим хүчний хэмнэлттэй техник технологи, туршлагыг ашигласан уу? <i>/эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, эрчим хүчний хэмнэлттэй барилга зэргийг ашиглах, дэвшилтэт зай бүхий тээврийн хэрэгсэл, түлшний элемент/цахилгаан зай, гибрид тээврийн хэрэгсэлийг хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
15	Танай байгууллага байгалийн нөөц, байгалийн нөөцийг орлох бүтээгдэхүүнийг нөхөн сэргээх, дахин ашиглах, боловсруулах технологийг ашигласан уу? <i>/хог хаягдлын материал (шил, металл, цаас, резин, хуванцар, олжмэл эдлэл зэрэг хоёрдогч түүхий эдийг цуглуулах, дахин ашиглах) үүсгэгчийг арилгах, байгалийн нөөцийн хэрэглээг бууруулах, бохир ус, хатуу хог хаягдлыг сайжруулах, хаягдал материалыг дахин боловсруулах технологи, туршлагын ашиглалтыг хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
16	Танай байгууллага байгаль орчны бохирдол, агаарт ялгаруулах хаягдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, арилгах техник технологи, туршлагыг ашигласан уу? <i>/химийн хортой бодис, бохирдол үүсгэгчийг бууруулах, устгах; бохирдуулагч, аюултай хог хаягдал (нүүрс төрөгчийн дутуу исэл, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл, гербицид, пестицид, хүнд металл, цацраг идэвхт бодис)-ыг байгаль орчноос зайлуулах технологи, туршлагын ашиглалтыг хамруулна. /</i>	Агаарын бохирдол А Усны бохирдол Б Бусад В (бичих)	
17	Танай байгууллага байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалах техник технологи, туршлагыг ашигласан уу? <i>/хөрс, гадаргын болон газар доорх усны хамгаалалт, нөхөн сэргээлт; ус болон бусад нөөцийн хэрэглээ (борооны ус ашиглалт)-г багасгах; биологийн олон янз байдал, ландшафтын хамгаалах; модны нөөц (зохистой ойн аж ахуйн туршлагыг оруулаад)-ийг хамгаалах, нөхөн сэргээх технологи, туршлагын ашиглалтыг хамруулна. /</i>	Агаар А Хөрс Б Усны нөөц В Ойн нөөц Г Ашигт малтмал Д Биологийн олон янз байдал Е	
18	Танай байгууллага хөдөө аж ахуйн салбарт нэвтэрсэн байгаль орчинд ээлтэй (тогтвортой) техник технологи, туршлагыг ашигласан уу? <i>/хөрсийг элэгдэл, эвдрэл (ус зайлуулах хоолойгүй усжуулалт бүхий тариалан эрхлэх, хөрсийг хэт их хагалах)-д оруулалгүй урт хугацаанд ашиглах туршлага; химийн бордоо, химийн хор зэргийг огт ашиглаагүй эсвэл маш бага хэмжээгээр ашиглан ургуулсан үр тариа, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, даавар, антибиотик, генетикийн өөрчлөлттэй организм, зохиомол хээлтүүлэг зэргийг огт ашиглаагүй эсвэл маш бага хэмжээгээр ашиглан мал аж ахуйг эрхлэх туршлагын ашиглалтыг хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
19	Танай байгууллага байгаль орчны чиглэлийн технологийн судалгаа, шинжилгээ, төлөвлөлт, хяналт, үйлчилгээ хийсэн үү? <i>/эрчим хүч, байгалийн нөөцийг хамгаалах, бохирдлыг бууруулах судалгаа, шинжилгээ; тэдгээрийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үнэлгээ; тэдгээртэй холбоотой дэд бүтцийн тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ; үр дүнг хянах, тодорхойлох үйл ажиллагааг хамруулна. /</i>	Тийм 1 Үгүй 2	
20	Танай байгууллага 13-19-р асуултад дурдаагүй байгаль орчинд ээлтэй техник технологи, туршлагыг ашигласан уу?	Тийм 1 Үгүй 2	
21	Танай байгууллагын 13-20-р асуултад дурдсан үйл ажиллагаанд оролцож, ажлын цагийнхаа 50.0-иас дээш хувийг зарцуулсан ажилчдынхаа тоог бичнэ үү	<input type="text"/> хүн	
22	Танай байгууллага байгаль орчны удирдлагын MNS-ISO-14001 стандартыг нэвтрүүлсэн үү?	Тийм 1 Үгүй 2	
23	Танай байгууллага байгаль орчны ажилтантай юу?	Тийм 1 Үгүй 2	
24	Танай байгууллага байгаль орчны дотоод аудитыг хэрэгжүүлдэг үү? <i>/Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126.дугаар тушаал /</i>	Тийм 1 Үгүй 2	

д/д	Асуулт	Хариулт		Алхам
25	13-20-р асуултад дурдсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, ажлын цагийнхаа 50.0-иас дээш хувийг зарцуулсан ажилчдын сарын дундаж цалин болон мэргэжлийг бичнэ үү.	мэргэжил	цалин	
				мян.төг
				мян.төг
				мян.төг
				мян.төг

Хэсэг 3. Санал, хүлээлт

26	Танай байгууллага байгаль орчны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний эрэлт, хэрэгцээ нэмэгдэнэ гэж бодож байна уу?	Тийм	1	
		Үгүй	2	
27	Танай байгууллага ногоон технологийн урт болон дунд хугацааны томоохон хөрөнгө оруулалтыг ашигтай байж чадна гэж бодож байна уу?	Тийм	1	
		Үгүй	2	
28	Танд "Ногоон" туршлагыг ажлын байрандаа хэрэгжүүлэхэд ямар саад тулгарч байна вэ? /нэг буюу түүнээс олон хариулт сонгож болно ./	Ажиллагчдын байгаль орчны үйл ажиллагаа/туршлагын мэдлэг, ур чадвар дутагдалтай	А	
		Сургалтын хөтөлбөр хомсдолтой	Б	
		Хэрэгжүүлэх зардал дутагдалтай	В	
		Ногоон технологийн хөрөнгө оруулалтын ашиг тодорхойгүй, зардлаа нөхөх хугацаа хэтэрхий урт	Г	
		Зах зээлийн эрэлт тодорхойгүй	Д	
		Мэдээлэл дутмаг	Е	
		Засгийн газрын бодлого/журам тодорхойгүй	Ё	
		Татаас, санхүүгийн урамшуулал хангалтгүй	Ж	
		Бусад	З	
29	Танай байгууллагад агаарыг бохирдуулагч болон бий болсон бохирдлыг арилгахад ямар мэдээлэл, тусламж хэрэгтэй гэж үзэж байна вэ? /1 буюу түүнээс олон хариулт сонгож болно ./	Агаарын бохирдлыг үр ашигтай бууруулах тодорхой арга хэмжээний тухай мэдээлэл	А	
		СО2-ын ялгарлыг үр ашигтайгаар бууруулсан ижил төстэй бизнесийн амжилтыг харуулсан мэдээлэл	Б	
		Агаарын бохирдлыг бууруулах санхүүжилт	В	
		Агаарын бохирдлыг амжилттай бууруулсан аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан урамшууллын хөтөлбөр	Г	
		Агаарын бохирдлын талаарх мэдээлэл	Д	
		Техникийн тусламж	Е	
		Бусад	Ё	
30	Танай байгууллага ажиллагчдынхаа байгаль орчны талаарх мэдлэгийн түвшинг хангалттай гэж үзэж байна уу?	Тийм	1	
		Үгүй	2	
31	Танай байгууллагын зүгээс байгаль орчны тогтвортой байдалд өндөр ач холбогдол өгч байна уу?	Тийм	1	
		Үгүй	2	
32	Та байгаль орчны салбар дахь ажил эрхлэлтийн тодорхойлолтыг боломжийн гэж үзэж байна уу? Та үүнд ямар саналтай байна вэ?	Тийм	1	
		Үгүй	2	
		Санал		
			
			